



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/106/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 99900662 Цахим хаяг: [baterdenee@audit.gov.mn](mailto:baterdenee@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 88095436 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Ньюбаланс аудит ХХК-ийн

Захирал: Б.Лхагвадорж [Newbalance.lhagvaa@gmail.com](mailto:Newbalance.lhagvaa@gmail.com).

Утас: 99101901

Аудиторын туслах: Ё.Байгалмаа [yobaigal5579@gmail.com](mailto:yobaigal5579@gmail.com)

Утас: 99025579

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

---

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.09.25 № 01/216  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨМӨРБУЛАГ  
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ А.АМАРЖАРГАЛ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>49,245,564.26</u></b>	<b><u>51,815,454.68</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	4,920,550.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,704,196.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	2,216,354.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	137,754.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,078,600.00	00.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	400,000.00	00.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	400,000.00	00.00
34713	Цалингийн урьдчилгаа	400,000.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	43,925,014.26	51,815,454.68
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	13,964,989.88	12,030,714.52
35110	Тусгай зориулалттай материал	12,354,239.88	8,546,643.52
35130	Эм боох материал	1,610,750.00	3,484,071.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	29,960,024.38	38,424,740.16
35410	Бичиг хэргийн материал	2,621,602.00	2,606,202.00
35420	Аж ахуйн материал	20,865,927.15	22,870,487.15
35450	Барилгын засварын материал	00.00	2,256,300.00
35460	Хүнсний материал	6,472,495.23	10,691,751.01
35600	Мал амьтад	00.00	1,360,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>176,914,006.72</u></b>	<b><u>178,920,406.90</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	176,914,006.72	178,920,406.90
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	167,634,006.72	169,640,406.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	156,374,093.03	156,374,093.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	-24,547,319.36	-36,717,932.59
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	53,351,801.87	53,548,445.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-36,290,773.72	-24,343,381.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,146,286.49	42,729,086.49
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,973,227.59	-24,583,949.61
39217	Ном	2,573,146.00	2,634,046.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	9,280,000.00	9,280,000.00
39301	Програм хангамж	275,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-275,000.00	-275,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,280,000.00	9,280,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>226,159,570.98</u></b>	<b><u>230,735,861.58</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>226,159,570.98</u></b>	<b><u>230,735,861.58</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	226,159,570.98	230,735,861.58
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	152,762,004.78	152,762,004.78

51101	Өмч: - төрийн	152,762,004.78	152,762,004.78
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>6,265,990.92</b>	<b>10,842,281.52</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	6,265,990.92	6,265,990.92
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	4,576,290.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	67,131,575.28	67,131,575.28
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>226,159,570.98</b>	<b>230,735,861.58</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>315,017,405.00</b>	<b>325,417,629.08</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>315,017,405.00</b>	<b>325,199,463.08</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,575,305.00</b>	<b>15,003,463.08</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,575,305.00	15,003,463.08
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,575,305.00	15,003,463.08
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>33,490,900.00</b>	<b>30,582,800.00</b>
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>278,951,200.00</b>	<b>279,613,200.00</b>
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	278,951,200.00	279,613,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>218,166.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>00.00</b>	<b>218,166.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	218,166.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>328,062,063.79</b>	<b>320,841,338.48</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>328,062,063.79</b>	<b>320,841,338.48</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>309,277,166.78</b>	<b>302,038,423.72</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>204,560,542.00</b>	<b>213,350,055.27</b>
210101	Үндсэн цалин	183,181,442.00	149,655,624.00
210102	Нэмэгдэл	9,379,100.00	49,392,779.27
210104	Урамшуулал	12,000,000.00	14,301,652.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,806,099.74</b>	<b>28,501,544.97</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,583,943.74	20,208,146.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,055,538.00	2,073,524.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,644,430.00	1,658,620.10
210204	Ажилгүйдлийн даатгал	411,108.00	414,804.38
210205	Эрүүл мэндийн даатгал	4,111,080.00	4,146,449.33
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,470,142.25</b>	<b>17,938,782.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	957,685.25	559,949.00
210302	Түлш, халаалт	18,380,657.00	17,323,833.00
210303	Цэвэр, бохир ус	131,800.00	55,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,039,604.92</b>	<b>11,384,634.36</b>
210401	Бичиг хэрэг	3,102,960.00	2,511,400.00

210402	Тээвэр, шатахуун	1,452,060.00	1,688,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	585,915.00	1,024,768.00
210404	Ном, хэвлэл	23,100.00	68,980.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,919,000.00	1,987,700.00
210408	Бараа материал акталсны зардал	9,756,569.92	3,903,736.36
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>15,832,905.10</b>	<b>5,606,144.22</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	133,540.00	502,164.00
210502	Хоол, хүнс	15,699,365.10	5,103,980.22
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>00.00</b>	<b>2,013,700.00</b>
210604	Урсгал засвар	00.00	2,013,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>00.00</b>	<b>70,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	00.00	70,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>350,000.00</b>	<b>848,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	308,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	540,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>23,217,872.77</b>	<b>22,325,562.90</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,430,100.00	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	170,000.00	160,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,617,772.77	21,665,562.90
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,784,897.01</b>	<b>18,802,914.76</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>662,500.00</b>	<b>400,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	662,500.00	400,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>9,891,142.76</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	9,891,142.76
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>13,883,003.75</b>	<b>8,511,772.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,883,003.75	8,511,772.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,239,393.26</b>	<b>00.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,239,393.26	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-13,044,658.79</b>	<b>4,576,290.60</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,078,600.00</b>	<b>00.00</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	2,078,600.00	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>2,078,600.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-10,966,058.79</b>	<b>4,576,290.60</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн

C01	<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	143,482,004.78	49,628,360.00	-9,391,953.23	183,718,411.55
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>143,482,004.78</b>	<b>49,628,360.00</b>	<b>-9,391,953.23</b>	183,718,411.55
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-11,734,966.11	-11,734,966.11
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>152,762,004.78</b>	<b>67,131,575.28</b>	<b>6,265,990.92</b>	226,159,570.98
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>152,762,004.78</b>	<b>67,131,575.28</b>	<b>6,265,990.92</b>	226,159,570.98
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>152,762,004.78</b>	<b>67,131,575.28</b>	<b>6,265,990.92</b>	226,159,570.98
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	4,576,290.60	4,576,290.60
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>152,762,004.78</b>	<b>67,131,575.28</b>	<b>10,842,281.52</b>	230,735,861.58

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>312,442,100.00</b>	<b>313,340,716.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>312,442,100.00</b>	<b>310,196,000.00</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	33,490,900.00	30,582,800.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	278,951,200.00	279,613,200.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	278,951,200.00	279,613,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>3,144,716.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	3,144,716.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	218,166.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,926,550.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>308,658,100.00</b>	<b>303,279,816.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>308,658,100.00</b>	<b>303,279,816.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>289,873,202.99</b>	<b>284,476,901.24</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>204,960,542.00</b>	<b>212,950,055.27</b>
210101	Үндсэн цалин	173,554,234.00	149,255,624.00

210102	Нэмэгдэл	16,518,708.00	49,392,779.27
210104	Урамшуулал	14,887,600.00	14,301,652.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,806,099.74</b>	<b>28,501,544.97</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,069,999.74	20,208,146.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,184,100.00	2,073,524.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,747,300.00	1,658,620.10
210204	Ажилгүйдлийн даатгал	436,800.00	414,804.38
210205	Эрүүл мэндийн даатгал	4,367,900.00	4,146,449.33
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,607,896.25</b>	<b>17,801,028.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	957,685.25	559,949.00
210302	Түлш, халаалт	18,518,411.00	17,186,079.00
210303	Цэвэр, бохир ус	131,800.00	55,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,731,075.00</b>	<b>4,423,498.00</b>
210401	Бичиг хэрэг	493,700.00	219,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,452,060.00	1,688,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	585,915.00	1,024,768.00
210404	Ном, хэвлэл	95,900.00	121,780.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,803,500.00	1,169,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>23,122,190.00</b>	<b>12,688,875.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,081,490.00	2,491,085.00
210502	Хоол, хүнс	15,853,000.00	7,466,990.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,187,700.00	2,730,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>50,000.00</b>	<b>4,270,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,000.00	00.00
210604	Урсгал засвар	00.00	4,270,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>00.00</b>	<b>70,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	00.00	70,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>350,000.00</b>	<b>848,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	308,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	540,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,245,400.00</b>	<b>2,923,900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	584,500.00	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,660,900.00	2,423,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,784,897.01</b>	<b>18,802,914.76</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>662,500.00</b>	<b>400,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	662,500.00	400,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>9,891,142.76</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	9,891,142.76

<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	13,883,003.75	8,511,772.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,883,003.75	8,511,772.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	4,239,393.26	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,239,393.26	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>3,784,000.00</b>	<b>10,060,900.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3,784,000.00</b>	<b>10,060,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,784,000.00</b>	<b>10,060,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	3,784,000.00	10,060,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,784,000.00	10,060,900.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-3,784,000.00</b>	<b>-10,060,900.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>310,196,000.00</b>	<b>291,793,101.24</b>	<b>18,402,898.76</b>	94.1%
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>310,196,000.00</b>	<b>291,793,101.24</b>	<b>18,402,898.76</b>	<b>94.1%</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>309,796,000.00</b>	<b>291,393,101.24</b>	<b>18,402,898.76</b>	<b>94.1%</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>215,116,500.00</b>	<b>212,950,055.27</b>	<b>2,166,444.73</b>	<b>99.0%</b>
210101	Үндсэн цалин	138,599,200.00	149,255,624.00	10,656,424.00	107.7%
210102	Нэмэгдэл	61,629,700.00	49,392,779.27	12,236,920.73	80.1%
210104	Урамшуулал	14,887,600.00	14,301,652.00	585,948.00	96.1%
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29,040,700.00</b>	<b>28,501,544.97</b>	<b>539,155.03</b>	<b>98.1%</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,436,100.00	20,208,146.98	227,953.02	98.9%
210202	Тэтгэмжийн даатгал	2,151,200.00	2,073,524.18	77,675.82	96.4%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,720,900.00	1,658,620.10	62,279.90	96.4%
210204	Ажилгүйдлийн даатгал	430,200.00	414,804.38	15,395.62	96.4%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,302,300.00	4,146,449.33	155,850.67	96.4%

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	26,310,100.00	17,801,028.00	8,509,072.00	67.7%
210301	Гэрэл, цахилгаан	3,500,000.00	559,949.00	2,940,051.00	16.0%
210302	Түлш, халаалт	21,810,100.00	17,186,079.00	4,624,021.00	78.8%
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	55,000.00	945,000.00	5.5%
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,628,400.00	4,484,398.00	144,002.00	96.9%
210401	Бичиг хэрэг	219,300.00	219,300.00	00.00	100.0%
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,688,050.00	111,950.00	93.8%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,056,800.00	1,024,768.00	32,032.00	97.0%
210404	Ном, хэвлэл	182,700.00	182,680.00	20.00	100.0%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	200,000.00	00.00	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,169,600.00	1,169,600.00	00.00	100.0%
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	16,185,300.00	9,544,175.00	6,641,125.00	59.0%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,273,100.00	2,272,935.00	165.00	100.0%
210502	Хоол, хүнс	11,181,200.00	4,540,440.00	6,640,760.00	40.6%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,731,000.00	2,730,800.00	200.00	100.0%
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14,272,700.00	14,270,000.00	2,700.00	100.0%
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00	00.00	100.0%
210602	Тавилга	5,000,000.00	5,000,000.00	00.00	100.0%
210604	Урсгал засвар	4,272,700.00	4,270,000.00	2,700.00	99.9%
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	182,700.00	70,000.00	112,700.00	38.3%
210702	Дотоод албан томилолт	182,700.00	70,000.00	112,700.00	38.3%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,132,400.00	848,000.00	284,400.00	74.9%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	592,400.00	308,000.00	284,400.00	52.0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00	00.00	100.0%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2927200.00	2923900.00	3,300.00	99.9%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	503,300.00	500,000.00	3,300.00	99.3%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,423,900.00	2,423,900.00	00.00	100.0%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	400000.00	400000.00	00.00	100.0%

2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	400,000.00	00.00	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	400,000.00	00.00	100.0%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	310,196,000.00	310,196,000.00	00.00	100.0%
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	279,613,200.00	279,613,200.00	00.00	100.0%
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	279,613,200.00	279,613,200.00	00.00	100.0%
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	30,582,800.00	30,582,800.00	00.00	100.0%
132001	Орон нутгийн төсвөөс	30,582,800.00	30,582,800.00	00.00	100.0%
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	18.00	18.00	00.00	100.0%
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	00.00	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	00.00	100.0%

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
		/ төгрөгөөр /
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,144,700.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,144,700.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,144,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,144,700.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	218,150.00
210502	Хоол, хүнс	2,926,550.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3144700.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,144,700.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	218,150.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,926,550.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### **3. Аудитын тайлан**

---

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ньюбаланс аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Лхагвадорж, аудиторын туслах Ё.Байгалмаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын чанарын менежер Д.Гэрэлчулуун гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Б.Давааням, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ньюбаланс аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн № 04 тоот дугаартай албан бичиг ирүүлсэн боловч тайлангаа 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдөр ирүүлсэн.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэг нь хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43-р тогтоол, “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэх тухай” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Төмөрбулаг сумын

Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 326.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.5 сая төгрөгөөр буюу 2 хувиар өссөн байна. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй байна.

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	4.9	0	-4.9
Бараа материал	43.9	51.8	7.9
Биет хөрөнгө	167.6	169.6	2.0
Биет бус хөрөнгө	9.3	9.3	0
<b>Нийт хөрөнгө</b>	<b><u>226.2</u></b>	<b><u>230.7</u></b>	<b>-4.5</b>
Дансны өглөг	0.0	0,0	0,0
Засгийн газрын хувь оролцоо	152.8	152.8	0
Хуримтлагдсан үр дүн	6.3	10.8	-4.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	67.1	67.1	0,0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b><u>226.2</u></b>	<b><u>230.7</u></b>	<b>-4.5</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 51.8 сая төгрөг болж, 7.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд эм боох материал, аж ахуйн материал, барилгын засварын материал, хүнсний материал зэрэг дансны үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ. Тайлант хугацаанд 3.9 сая төгрөгийн тусгай зориулалтын материал актаар хассан байна.

Биет хөрөнгийн дансны үлдэгдэл 169.6 сая төгрөг болж, 2.0 сая төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой.

Дансны өглөг данс үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо данс 152.8 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 10.8 сая төгрөг, Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 67.1 сая төгрөг байна.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 325.4 сая төгрөг, нийт зардал 320.8 сая төгрөг, тайлант үеийн үр дүн 4.6 сая төгрөг байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд дахин үнэлгээтэй хөрөнгө хасагдсантай холбоотой хуримтлагдсан үр дүнд нөлөөлөөгүй байна. Нийт цэвэр өмчийн дүн 230.7 сая төгрөг байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэг 2021 оны төсвийн төслийг 471.2 сая төгрөгөөр тооцон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна. Тайлант онд 369.1 сая төгрөгөөр анх баталж, 48.7 сая төгрөгөөр төсвийн тодотгол хийж, 291.8 сая төгрөгийн төсөв баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд 291.8 сая төгрөг батлагдсанаас 310.2 сая төгрөгийн урсгал санхүүжилт авч, 291.8 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж 18.4 сая төгрөг хэмнэж орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсвөөс 10 хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны орлого 2.9 сая төгрөг, Боловсролын газраас ариутгал халдвар хамгаалалд зориулан 0.2 сая төгрөгийг тус тус хүлээн авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Дэлхий нийтийг хамарсан Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, хөл хорионы үед цэцэрлэгүүд хичээлэхгүй байх, мөн хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөх эрсдэл үүссэн. Ковидтой холбоотой төсвийн хэтрэлт хэмнэлт гарч төсвийн зохицуулалт хийгдсэн.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь Засгийн Газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж 18.4 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна. Үүнд: Цалин хөлс болон НДШ-с 2.7 сая төгрөг, тогтмол зардлаас 8.5 сая төгрөг, хоол хүнсний зардлаас 6.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрөөс 06 сая төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд 16 мэдээлэлийг хугацаа хоцроож дутуу мэдээлсэн байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн зарим хуулийн нийцлийн Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ын хэрэгжилтийг хянан үзлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн Эрхлэгч, нягтлан бодогч нар нь санхүүгийн тайлангаа төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” дэх цаглаварт хугацаанд ирүүлээгүй хугацаа хоцроож 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдөр ирүүлсэн тул Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” дэх заалтыг үндэслэн хариуцлага тооцох албан шаардлагыг Төмөрбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар нийт 2 алдаа зөрчил илэрснээс, 2 зөвлөмж өгсөн болно.

### **4.1 Залруулсан алдаа**

Залруулсан алдаа байхгүй болно.

### **4.2 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### **4.3 Албан шаардлага**

Албан шаардлага байхгүй болно.

### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Санхүүгийн тайлантай холбоотой**

1.1 Илрүүлэлт: 2021 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь иж бүрэн ирүүлэхэд анхаарах нь зүйтэй.

#### **2 Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой**

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

- 2.1 Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд 16 мэдээлэлийг хугацаа хоцроож дутуу мэдээлсэн байна.
- 2.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ"-д заасан мэдээллийг тухай бүр нэгдсэн системд мэдээлж байх,
- 2.3 Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэг	2						1		1	



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

ХЯНАСАН:

А.ЭРДЭНЭБААТАР

Э.БАТ-ЭРДЭНЭ

Б.ДАВААНЫМ

БЭЛТГЭСЭН:

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

АУДИТОРЫН ТУСЛАХ

Б.ЛХАГВАДОРЖ

Д.ГЭРЭЛЧУЛУУН

Ё.БАЙГАЛМАА